

Бөөрний нуугдсан халуун өвчний эмийн эмчилгээг зарим сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлүүдийн хүрээнд харьцуулсан шинжлэл

А.Сундуйжамц¹, С.Сээсрэгдорж²

¹АШУҮИС, МАУОУС, Монгол Анагаах Ухаан Судлалын тэнхим

²АШУҮИС, МАУОУС, Монгол Анагаах Ухааны Дотор өвчин судлалын тэнхим

Цахим шуудан: Sundui870@gmail.com, Утас: 99069147

Түлхүүр үг:

Бөөр
Нуугдсан халуун
Эмчлэх зарчим
Эмийн эмчилгээ

Товч утга:

Үндэслэл: Уламжлалт анагаах ухаанд өвчнийг ерөнхийдөө халуун, хүйтэн хоёрт хураангуйлж ангилаад халуун чанартай өвчнүүдийг хамгийн эхэнд нь таньж мэдэхийг онцгойлон үзсэн байдаг. Энэ хүрээнд бид оношлоход төвөгтэй, эндүүрэл их гардаг, халуун, хүйтэн аль ч тал руугаа сэдэрч хүндэрч болох, эмчилгээ нь олон үе шаттай хийгддэг, эмнэл зүйд олон тохиолддог бөөрний нуугдсан халуун өвчнийг судлах нь онол, эмнэл зүйн ач холбогдол ихтэй хэмээн үзлээ. **Зорилго:** Уламжлалт анагаах ухааны зарим сурвалж тэдгээрийн тайлбарууд, мэргэдийн бүтээлүүдийн хүрээнд бөөрний нуугдсан халуун өвчнийг анагаах зарчим, эмийн эмчилгээний талаар харьцуулан шинжлэх. **Арга, аргачлал:** Эх хэрэглэгдэхүүн анагаах ухааны дөрвөн үндэс, түүний тайлбар, мэргэдийн нийт 6 бүтээлүүдийн бөөрний нуугдсан халуун өвчний эмчилгээний зохих бүлгүүдийг эх бичиг судлалын герменевтик, харьцуулах, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх аргаар энэхүү судалгааг хийлээ. **Үр дүн:** Судалгааны эх хэрэглэгдэхүүн эх бичгүүдэд Бөөрний нуугдсан халуун өвчний эмчилгээний зарчмыг ерөнхийдөө 1. Анханд нь их хулгайчийг нүхэнд оруулах. 2. Завсарт нь утааг яндангаар гаргах. 3. Эцэст нь халууны үлдэгдлийг усаар нядлах хэмээн гүн агуулгатай гурван үе шаттай эмчилгээ хийхээр заажээ.¹ Эдгээр зарчим тус бүрд тохирсон эмчилгээ оновчтой байгаа нь уламжлалт анагаах ухаан тус өвчнийг өөрийн онол, аргазүйн хүрээнд эртнээс төгс чанартай таньж мэдэж эмчилж ирснийг нотолж байна. Судалгааны эх хэрэглэгдэхүүн болох эх бичгүүдэд бөөрний нуугдсан халууныг анагаах нийт 33 найрлага бичигдсэнийг эмийн хэлбэрээр авч үзвэл тан 5, талх 26, тосон эм 2 нийт 33 эм байгаа нь сонголт ихтэй байгааг харуулж байна. Эдгээр эмүүдийг өвчний гурван зарчмын дагуу эхлээд бадган, хийн бүрхүүлийг хуулахад Жуган дэжид, Сэмбэрүү-4, утааг яндангаар гаргахад тан эмийн хэлбэрийг сонгосны зэрэгцээ талх эмийг өвчний халууны дээд, дунд, доод хүчинд тохируулан хэрэглэхээр заасан нь түлхүүр цоож таарах мэт тохирч байна. Уламжлалт анагаах ухааны эмчилгээнд өвчний сүүлийг таслах буюу эмчилгээний төгсгөлд бие махбодыг сэргээж арга билгийг тэнцүүлэх зорилготой тосон эмийг хэрэглэж ирсэн нь өвөрмөц онцлог болж байна. Судалгааны эх хэрэглэгдэхүүн болгосон эх бичгүүдийг харьцуулахад Бөөрний нуугдсан халуун өвчнийг анагаах эмчилгээний зарчим түүнд тохирх эмүүдийг сонгосон байдал нь “АУДҮ” сурвалжийг баримтлахын зэрэгцээ өөрсдийн зохих нэмэлтүүд хийсэн нь байна. **Дүгнэлт:** Эмийн эмчилгээг харьцуулж шинжлэхэд эмчилгээний гурван зарчмын дагуу хэрэглэх эмүүдийн хэлбэр, тэдгээрийн бүрэлдэхүүнийг тодорхой зааж өвчний хүчинд тохируулан өгөх эмээ хүчээр нь зааж нэрлэсэн нь ялгавартай төдийгүй тохирч байгаа нь төгс чанартай стандарт эмчилгээ болохыг илэрхийлж байна.

Үндэслэл: Халуун өвчин дэлгэрэх нь түргэн, түүнийг үүсгэгч нөхцөл олон учир тамир, хир бүгдэд зэрэг түгсний эрхээр олон зүйлийн халуун өвчин үүсдэг. Тийм учраас халуун өвчнийг бодитой таньж оношлох, анагаахад бэрхтэй бөгөөд дэлгэрэх нь хялбар үтэр түргэн амийг булаадаг тул үүнийг эн түрүүн мэдэх хэрэгтэй гэж уламжлалт анагаах ухааны сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлд онцгой анхааруулсан байдаг.^{1,2} Харин эдгээр халуун өвчнүүдийн дотроос нуугдсан халуун өвчний мөн чанар нь үнсний дотор нуугдсан цог адил байдаг нь бөөрний өөрийн үүсгэдэг шороо, усан махбодын улмаас хүйтэн, хий хоёр халууны толгойг бүрхэж бадган хийн доор халуун халхлагдаж оношлоход төвөгтэй өвчин үүсэх нь олон байдаг гэж тэмдгэлсэн байна.^{1,2} Учир нь бөөр ерөнхий хийн оронд оршихын зэрэгцээ усан махбод голлон гүйдэг тул халуун өвчин үүссэн ч хүйтэн, хийн орны эрхээр гаднаа хүйтний хуурамч шинж бүхий халуун нь ёроолдоо нуугдсан өвчин их үүсдэг.

Иймээс халуун дарагдалгүй урхаг нь хоцорч идээ явдал мөр, тэргүүтэй нөхцөлтэй учирваас галын цог уул өвстэй учрах мэт нэг агшинд ихэд арвидсан халуун өвчин болж дэлгэрч хүндрэх эсвэл эсрэгээрээ хүйтэнд урвах болно.^{1,2} Уламжлалтын эх бичгүүдэд анхааруулсан байдагт үндэслэн энэ талаар сурвалж судлалын хүрээнд судлах нь бөөрний халуун өвчний эмгэг жам, эмчилгээний зарчим, эмийн эмчилгээг нэгдмэлээр судлах нь практик ач холбогдолтой хэмээн үзлээ.

Зорилго: Уламжлалт анагаах ухааны зарим сурвалж тэдгээрийн тайлбарууд, мэргэдийн бүтээлүүдийн хүрээнд бөөрний нуугдсан халуун өвчнийг анагаах зарчим, эмийн эмчилгээний талаар харьцуулан шинжлэх.


Зорилт:

1. Бөөрний нуугдсан халуун өвчнийг анагаах зарчмыг сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлүүдийн хүрээнд харьцуулан шинжлэх.
2. Бөөрний нуугдсан халуун өвчний үеийн эмийн эмчилгээг сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлүүдийн хүрээнд харьцуулан шинжлэх.

Арга, аргачлал: Анагаах ухааны дөрвөн үндэс / Увдисын үндсийн 12-р, 18-р бүлэг, Хойдын үндсийн 4-р бүлэг, Төвөд хэлээр/, Хөх биндэрьяа /Увдисын үндсийн 12-р, 18-р бүлэг, Хойдын үндсийн 4-р бүлэг,Төвөд хэлээр/, Увдисын үндсийн нэмсэн арга /Увдисын үндсийн 21-р бүлэг, Төвөд хэлээр/, Тус амгалангийн сэрүүн гэрэлт шинэ сар /Увдисын үндсийн 16-р бүлэг, Төвөд хэлээр/, Увдисын эрдэнэ гарах орон /Увдисын үндсийн 18-р бүлэг, Төвөд хэлээр/, Дөрвөн үндсийн тайлбар дээдсийн аман зарлиг /Увдисын үндсийн 18-р бүлэг, Төвөд хэлээр/ тэргүүтэй бүтээлүүдийн эх хэрэглэгдэхүүн болголоо.

Энэхүү судалгааг Сэдвээр бүлэглэх аргаар судалгааны эх хэрэглэгдэхүүний бүтэц, өгүүлэмжийн утгыг хоёуланд нь тодорхойлдог онцлогтой.³⁻⁵ Герменевтик аргаар эх бичгийг орчуулан утгыг тодорхойлох, тайлбарлах бөгөөд бид нуугдсан халуун өвчний мөн чанарыг тогтооход ашигласан.^{6,7-9} Харьцуулан жиших аргаар судраас хайж олсон эх хэрэглэгдэхүүнүүдийг хооронд нь харьцуулж адил, ялгаатай, хэрхэн уламжлагдсаныг¹⁰⁻¹² илрүүлэхэд ашиглан АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2024 оны 11-р сарын 21-ний өдрийн судалгааг эхлүүлэх ёс зүйн зөвшөөрөл /24-25/03-01/ ёсоор хийлээ.

Үр дүн: Судалгааны эх хэрэглэгдэхүүнүүдэд ерөнхийдөө нуугдсан халуун өвчнийг анагаах ёсыг I.Анханд нь их хулгайчийг нүхэнд оруулах; II.Завсарт нь утааг яндангаар гаргах; III.Эцэст нь халууны үлдэгдлийг усаар нядлах хэмээн гурван үе шаттай эмчилгээ хийхээр заажээ¹. (Зураг 1)



Зураг 1. Нуугдсан халууныг анагаах ёс

Харин “Хөх биндэрьяа” болон “Дөрвөн үндсийн тайлбар дээдсийн аман зарлиг хэмээх оршвой”-д эхний “Их хулгайчийг нүхэнд оруулах” зарчмаар эмчлэхдээ өвчний гэм ямар хувьтай байгааг ялгаж оношлоод зохистой идээг шүтүүлж гаднах бадган, хийн бүрхүүлийг хуулах талаар илүү зохистой өгүүлжээ. Ингэж гадагш гаргах зохистой буюу бүрхүүлийг хуулсны дараа тохирох сэрүүн ерөндгийг шүтүүлж халууныг дотор нь нядалж, гадагш түлхэх нь өвчний цусыг ялгах тухай болохыг тодорхой өгүүлсэн нь практик ач холбогдолтой байна. Хоёр дахь үе шатны эмчилгээг гэрээс яндангаар утааг гаргах зарчмаар хануур, туулгын аль зохистойг хэрэглэж урхгийг гаргана. Гурав дахь эмчилгээний шатанд эцэст нь галын нурмыг ус цацаж унтраах адил сэрүүн эмийг

үргэлжлүүлэн өгөхөөр заасан байна. Ингэж бөөрний нуугдсан халуун өвчнийг ахуй үес /үе шатанд/-д харгалзан гурван өөр зарчмаар эмчилгээ тус бүрийг тодорхой тайлбарласныг хураангуйлж үзвэл бадган, хийгээр халууны толгой бүрхэгдэж халуун далдлагдсан үед эхлээд явдал мөр, идээгээр бүрхүүлийг хуулж, дараа нь сэрүүн эмээр дотор нь ялгаж, гуравдугаарт хануур, туулгаар өвчин тэрийг бодитой гаргана хэмээн эмчилгээ гурван үе шаттай явагдахыг дэс дараа бүхий заасан нь эмнэл зүйн ач холбогдол ихтэй байна.^{2,13}

Эмийн эмчилгээг харьцуулан шинжлэхэд “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Тус амгалангийн сэрүүн гэрэлт шинэ сар”, “Увдисын үндсийн нэмсэн арга”, “Хөх биндэрьяа”, “Увдисын эрдэнэ гарах орон” эх бичгүүдэд бөөрний нуугдсан халууныг анагаах нийт

33 найрлага бичигдсэнийг эмийн хэлбэрээ бүлэглэвэл тан 5, талх 26, тосон эм 2 байна. Эх хэрэглэгдэхүүнийг бичигдсэн цаг хугацааны хамаарлаар^{14,6} авч үзвэл үндсэн эх хэрэглэгдэхүүн “Анагаах ухааны дөрвөн үндэс”-т 9 найрлага дээр ялгаатай 9 эм нэмэгдэж

бичигдсэн нь “Тус амгалангийн сэрүүн гэрэлт шинэ сар”-д 4, “Увдисын үндсийн нэмсэн арга”-д 2, “Увдисын эрдэнэ гарах орон”-д 3 нийт 18 найрлага бичигджээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Нуугдсан халууныг дарах эмийн найрлагыг ангилсан байдал

	Анагаах ухааны дөрвөн үндэс /VIII зуун/	Тус амгалангийн сэрүүн гэрэлт шинэ сар /VIII зуун/	Увдисын үндсийн нэмсэн арга /XVII зуун/	Хөх биндэрьяа /XVII зуун/	Увдисын эрдэнэ гарах орон /XIX зуун/	Нийт
Тан	1	-	-	1	3	5
Талх	7	4	4	7	4	26
Тосон эм	1	-	-	1	-	2

Эдгээрээс анагаах эхний зарчмын дагуу толгойн бүрхүүлийг хуулах ерөнхий эмийг Жугандэжид, Сэмбэрүү-4 хэмээн дөрвөн эх бичигт адил заажээ. Харин “Увдисын үндсийн нэмсэн арга” тайлбарт ганцхан Сэмбэрүү-4-ийг, хожим XVII, XIX зууны үед бичигдсэн “Хөх биндэрьяа”, “Увдисын эрдэнэ гарах орон”-д ганцхан Жугандэжид чимо-г заасан ч алийг ч хэрэглэж болох нь тодорхой байна.^{14,6}

Бөөрний нуугдсан халууныг анагаах тан эмийн хэлбэрийг хоёр эх хэрэглэгдэхүүнд адил заасанд шинжлэл хийхэд I.Халууныг нядалж, гадагш түлхэх

II. Муу цусыг ялгах хоёр үйлдэлтэй байна. Харин “Увдисын эрдэнэ гарах орон”-д заасан тан эм нь мөн адил I. Халууныг дарж, II. Муу цусыг ялгах үйлдэлтэй байгаач хуучин бурмаар хачир тавьж хэрэглэхээр заасан нь ялгаатай бөгөөд хийн бүрхүүл их үед илүү сонголттой байна.¹⁵ Тан эмүүдийн үзүүлэх үйлдэлд шинжлэл хийхэд амт, чадал нь хий+шарыг хамтад анагаах ба гашуун эхүүн, амтлаг амтнаас үүсэх сэрүүн, мохдог эрдмээрээ шарын халуун, хурц бэлгэ чанарыг дарах үйлдэл илүү байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Нуугдсан халууныг дарах тан эмийн найрлага

Сурвалж	Амт	Чадал	Найрлага
Анагаах ухааны дөрвөн үндэс /VIII зуун/	Гашуун, эхүүн	Сэрүүн, мохдог	Гурван үр, балига, удвал, лидэр, дэгд, бонагар, гадур, башигын ширгээсэн тан
Хөх биндэрьяа /XVII зуун/	Гашуун, эхүүн	Сэрүүн, мохдог	Гурван үр, балига, удвал, лидэр, дэгд, бонагар, гадур, башигын ширгээсэн тан
	Амтлаг, гашуун	Хүнд сэрүүн	Бридасайзан, жицэр, бүшилзийн ширгээсэн тан
Увдисын эрдэнэ гарах орон /XIX зуун/	Амтлаг, гашуун	Хүнд сэрүүн	Лидэр, лаган, дэгдийн тан
	Гашуун, эхүүн	Сэрүүн, мохдог	Гурван үрийн хувь тэнцүү ширгээсэн тан дээр хуучин бурам тавиад өгнө

Харин бөөрний нуугдсан халууныг дарах талх эмийг дээд халуун, дунд халуун, доод халууныг дарах гэж халууны хүчтэй нь холбож ангилсан нь онцлог бөгөөд өвчний халууны хүчтэй нь тохируулж өгөхөөр заасан нь эмийн хүчний үйлдэл нь тохирч эмчилгээ илүүдэх, дутагдах, буруудахаас сэргийлсэн онцгой ач холбогдолтой байна.^{1,2,16}

Дээд халууныг дарах талх эмийн хэлбэрийн бүрэлдэхүүнийг хоёр эх хэрэглэгдэхүүнд ижил утгатай байгаа нь “Хойдын үндэс”-ийн талх эмийн бүлэгт¹ түүнийг халууныг дарах “Хаан” адил гаврын “Зэрлэг хүн мэт дан ганцаар гүйх” найрлага гэжээ.¹ Дунд халууныг дарах эмийн бүрэлдэхүүнийг хоёр эх хэрэглэгдэхүүнд ижил утгатайгаар халууныг дарах “Түшмэл адил” Гүргэм-7-гийн найрлага гэжээ.¹ Доод халууныг дарах талх эмийг хоёр эх хэрэглэгдэхүүнд адил халууныг дарах хэсэг бусад элдэв харцын найрлага

гэжээ.¹ Харин “Увдисын үндсийн нэмсэн арга” тайлбарт заасан талхан эм нь бүрэлдэхүүний хувьд ялгаатай ч мөн адил халууны дарах үйлдэлтэй байгаад хачир нэмээгүйгээрээ ялгаатай байна. Шинжлэл хийж үзвэл нийт талх эмийн чадал нь сэрүүн, хөнгөн, мохдог байгаа нь хий, шарыг хамтад дарах ба гашуун, эхүүн амтны сэрүүн, мохдог эрдмээрээ шарын халуун, хурц бэлгэ чанарыг дарах үйлдэлтэй байна. (Хүснэгт 3)

Бөөрний нуугдсан халууныг анагаах эмүүдийн түүхий эдүүдэд шинжлэл хийхэд эмийн 8-н аймгаас шимийн эм, модон эм, өвсөн эмийн аймагт багатах хөл эмүүд байна. Хөл эмүүдийг амтаар нь шинжлэхэд үндсэн 6 амтаас гашуун, эхүүн, амтлаг гурван амтаар шарыг дарах, исгэлэн, халуунаар бадганыг дарах хам үйлдэлтэй байгаа нь тус бөөрний нуугдсан халуун өвчнийг үүсгэж байгаа шалтгааны дарах үйлдэлтэй болох нь тодорхойлогдож байна.

Хүснэгт 3. Нуугдсан халууныг дарах талхан эмийн найрлага

Сурвалж	Ангилал	Амт	Чадал	Найрлага
Анагаах ухааны дөрвөн үндэс /VIII зуун/	Дээд халуун	Гашуун, Халуун	Сэрүүн, Хөнгөн	Гавар, агар, гурван сэрүүн, дэгд, бона, лигадүрийг гаратай найруулан өгнө.
	Дунд халуун	Гашуун, Эхүүн	Сэрүүн, Мохдог	Гиван, зандан, гурван сэрүүн, арүр, ларьз бонагарвыг гаратай найруулан өгнө.
	Доод халуун	Гашуун, Амтлаг	Сэрүүн, Хүнд	Гүргэм, жуган, дэгд, арүр, барагшин, удвал, зээргэнэ, балэгыг гаратай найруулан өгнө.
Хөх биндэрьяа /XVII зуун/	Дээд халуун	Гашуун, Халуун	Сэрүүн, Хөнгөн	Гавар, агар, гурван сэрүүн, дэгд, бона, лигадүрийг гаратай найруулан өгнө.
	Дунд халуун	Гашуун, Эхүүн	Сэрүүн, Мохдог	Гиван, зандан, гурван сэрүүн, арүр, ларьз бонагарвыг гаратай найруулан өгнө.
	Доод халуун	Гашуун, Амтлаг	Сэрүүн, Хүнд	Гүргэм, жуган, дэгд, арүр, барагшин, удвал, зээргэнэ, балэгыг гаратай найруулан өгнө.
Увдисын үндсийн нэмсэн арга /XVII зуун/	Доод халуун	Амтлаг, Исгэлэн, Халуун	Хүнд, Халуун, Хөнгөн	Жуган, гүргэм, лишь, удвал, сэмбэрү, библин, шинца найруулан халуун усаар даруулж өгнө.

Чадлаар шинжлэхэд хүнд, сэрүүн, мохдог тэргүүтнээр хий, шарыг хамтад нь дарж байгаа нь бөөрний нуугдсан халууны шалтгаан болох хий, галыг хамтад нь дарж байгаа нь илэрч байна.

Бөөрний нуугдсан халууныг анагаах жоруудаас хамгийн их давтамжтай орж буй хөл эмүүдийг тогтоогоод эрдмээр шинжлэхэд шарыг дарах гашуун, эхүүн, амтаас үүсэх мохдог, сэрүүн эрдэм давамгайлж байгаа нь шарын хурц, халуун бэлгэ чанарыг дарах үйлдэл нь илүү байна. (Хүснэгт 4)

Бөөрний нуугдсан халуун өвчний сүүлийг тасалж бие махбодын арга билгийг тэнцвэржүүлэх талх эмийг дөрвөн эх сурвалж бичигт ижил, харин “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Хөх биндэрьяа” тайлбарт эмийн хөлгийг гара /мөсөн чихэр/-тай найруулан өг гэж заажээ. Үүнд шинжлэл хийхэд “Номлолын үндсийн 20-р бүлэгт” мөсөн чихэр нь цус, шарын халууныг дарах хөлөг хэмээгээд амт чадлаар нь хүнд, хөнгөн халууныг дарна.^{1,2} Мөн халуун, амтлаг амтаараа илчийг үүсгэж шингээх үйлдэлтэй байгаа нь бөөрний халуун дийлэнх нуугдсан халуунд илүү сонгож хэрэглэх нь зохимжтой болохыг илэрхийлж байна.

Хүснэгт 4. Хамгийн их давтамжтай илэрсэн эмт бодисын амт, чадал, тус эрдэм

Эмт бодис	Язгуурын ангилал	Амт	Чадал	Тус эрдэм
Гавар	Шимийн эмийн аймаг	Халуун, Эхүүн	Хөнгөн, Мохдог	Халуун дэлгэрсэнд аянга буулгаж наядална. Хуучирсан, шунасан халууныг угаас гаргана.
Гүргэм	Шимийн эмийн аймаг	Амтлаг	Хүнд, Мохдог	Элэгний өвчин бүгдийг арилгана судлын амыг бооно.
Арүр	Модон эмийн аймаг	Гашуун, Эхүүн	Сэрүүн, Мохдог	Хий, шар, бадганаас болсон өвчин бүгдийг дарна.
Бар үр	Модон эмийн аймаг	Гашуун, Эхүүн	Сэрүүн, Мохдог	Бадган шар шар усыг арилгана.
Жүр үр	Модон эмийн аймаг	Исгэлэн, Гашуун	Халуун, Хуурай	Бадган, шар, цусны өвчнийг арилгана.
Лидэр	Модон эмийн аймаг	Амтлаг, Гашуун, Эхүүн, Халуун	Хүнд, Сэрүүн, Мохдог	Хийн халууныг арилгана.
Цагаан зандан	Модон эмийн аймаг	Халуун, Эхүүн	Хөнгөн, Мохдог	Уушги зүрхний хаямарсан халууныг арилгана.
Дэгд	Өвсөн эмийн аймаг	Гашуун	Сэрүүн	Элэг цөсний халууныг арилгана.

Мөн бөөрний нуугдсан халууныг анагаахад дэгдийн тосон эм өгөхөөр “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Хөх биндэрьяа”-д тус тус заасан нь шарын халууны үлдэгдлийг усаар нядлах зарчмыг хангаж байна.

Хэлцэмж: Уламжлалт анагаах ухааны сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлүүдэд Бөөрний нуугдсан халуун өвчнийг үнсний дотор нуугдсан гал адил хүйтэн, хий хоёроор халууны толгойг бүрхсэнээр бадган хийн доор халууны шинж халхлагддаг буюу дарагддаг гэж тодорхойлсон нь харахад галын үнс мэт

мөртлөө хутгаад үзвэл тэнд цог байгаа өвчин болохыг оновчтой томъёолжээ.^{1,2}

Судалгааны эх хэрэглэгдэхүүний хүрээнд харьцуулж шинжлэхэд ерөнхийдөө “Анагаах ухааны дөрвөн үндэс” сурвалжийг баримталсан байна. Харин “Хөх биндэрья”, “Дөрвөн үндсийн тайлбар дээдсийн аман зарлиг хэмээх оршвой” бүтээлүүдэд эмчилгээний үе шат, зарчмыг илүү нарийн тодорхой заасны зэрэгцээ гарч болох эрсдэлийг анхааруулж сэрэмжлүүлсэн нь ач холбогдолтой байна. Мөн “Хөх биндэрья”-д машинд нарийнаас нарийнд эмээр толгойн бүрхүүлийг хуулахад ерөнхий болон ялгавартай зарчмаар хуулах тухай заагаад ерөнхий эм нь Хойдын үндэст үзүүлсэн Жуган дэжид чэмо хийгээд Сэмбэрүү-4 болох ба ялгавартай дор толгойн бүрхүүлийг хуулахдаа бодитой нуугдсаныг эрэхдээ эхлээд нуугдсан газраар нь хөглөх, дараа нь таних эцэст нь мухрыг эрэх гэсэн гурван зарчмаар олон үе шаттайгаар толгойн бүрхүүлийг хуулах ёстой гэж заасан нь онцлог байна.² Эхний бүрхүүл хуулах зарчим нь бадган хийг дараад өвчнийг голомтлог байдалд оруулж эмчилж буй өвөрмөц арга болохыг илэрхийлж байна. Нуугдсан халууныг дарах талх эмийг “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Хөх биндэрья”-д халууны хүчээр нь дээд, дунд, доод гэж ангилаад өгөх эмээ ялгавартай зааж тодорхойлсон нь эмчилгээний явцад эм илүүдэж хордуулах, эмийн хүч дутагч өвчин архагших, эм буруудаж өөр өвчинд шилжих эрсдэлээс урьдчилан сэргийлэх тохирсон төгс чанартай стандарт эмчилгээ уламжлалт анагаах ухаанд хийгдэж ирснийг тодорхойлж байна.^{1,2}

Бөөрний нуугдсан халууны хүчинд тохируулан Дээд халууныг дарах “Хаан” адил гаврын “Зэрлэг хүн мэт дан ганцаар гүйх” найрлага, “Тус амгалангийн сэрүүн гэрэлт шинэ сар”-д Гавар-7 дээр нэмж “Цэргийн ноён мэт өмөг их нөхрөөр хүрээлүүлэх^{1,2} “Гавар-9 болох ба үүнийг гавартай найруулж “Дүдзи силшүн” болно хэмээн шатлан найруулах аргыг тодорхой заасан нь практик ач холбогдолтой байна.¹⁷

Харин дунд халууныг дарах эмийг “Тус амгалангийн сэрүүн гэрэлт шинэ сар” –д Гүргэм-7 гээд дээр нь зандан нэмэхэд¹⁷ “Түшмэл адил найрлага болно.^{1,2} Доод халууныг дарах талх эмийг хэсэг бусаг элдэв харцын найрлага хэмээжээ. Харин “Увдисын үндсийн нэмсэн арга”-д хий+халууны бага хүчтэйг дарах түшмэл Гүргэм-7-гийн найрлага¹⁵, “Тус амгалангийн сэрүүн гэрэлт шинэ сар”-д Гиван-8-г¹⁷

“Ноён адил эрхэм наймын” найрлага хэмээн өвчний хүчинд тохируулан өгөх эмээ хүчээр нь зааж нэрлэсэн нь ялгавартай төдийгүй түлхүүр, цоож таарах мэт тохирч байна.²

Дүгнэлт:

1. Бөөрний нуугдсан халуун өвчнийг гурван үе шаттай эмчлэх зарчмыг тодорхой гүн агуулгатай заагаад түүнд тохирсон эмчилгээ оновчтой байгаа нь уламжлалт анагаах ухаан тус өвчнийг өөрийн онол, аргазүйн хүрээнд эртнээс төгс чанартай таньж мэдэж эмчилж ирснийг нотолж байна.
2. Эмийн эмчилгээг харьцуулж шинжлэхэд эмчилгээний зарчмын дагуу хэрэглэх эмүүдийн хэлбэр, тэдгээрийн бүрэлдэхүүнийг тодорхой зааж өвчний хүчинд тохируулан өгөх эмээ хүчээр нь зааж нэрлэсэн нь ялгавартай төдийгүй түлхүүр, цоож таарах мэт тохирч байгаа нь төгс чанартай стандарт эмчилгээ болохыг илэрхийлж байна.

Ном зүй:

1. Ёндонгомбо Ю. Рашааны Шим Найман гишүүнт нууц увдисын үндэс хэмээх оршвой. . Улаанбаатар 2014.
2. Санжаажамц Д. Хөх Биндэрья. Улаанбаатар 2005.
3. Н.Батсайхан. Монгол уламжлалт анагаах ухаан: Зарим эх сурвалжийн нягтлан шинжлэл. Монгол улс 2021.
4. Ч.Авдай ДЭ. Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй. 2013.
5. Н.Батсайхан СС. Нэгтгэмэл Анагаах Ухааны Монгол сэтгүүл. 2021;8(2):73.
6. Я. Г. Дөрвөн үндсийн гарсан ёс. 2007.
7. Д.Т. Эрдмийн бүтээл туурвих арга зүйн зөвлөмж. 2007.
8. Г.Л. Философи ба шинжлэх ухааны арга зүй. Монгол улс 2002.
9. Сээсрэгдорж.С. Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн язгуурын үндэс болон түүний тайлбар зохиолуудад хийсэн дүн шинжлэл”. Монгол улс 2002.
10. Д.Дашжамц. Шинжлэх ухааны судалгааны ажлын онол-арга зүйн үндэс. Монгол улс 2017.
11. И.К. К. Методы исторического исследования. 2003.
12. Ш.Б. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. Монгол улс 2006.
13. Лодойжалбо С. Дөрвөн Үндсийн Тайлбар Дээдсийн Аман Зарилга. Vol 19-р боть. Бээжин 2005.
14. Жигмэд.Б. Монгол анагаах ухааны түүх болон эртний сурвалж бичгийн шинжилгээ Монгол улс 2009.
15. Жамбалчойжиданзанпринлэй. Увидас эрдэнэ гарах орон Vol 53-р боть. Бээжин 2006.
16. Санжаажамц Д. Увидсын Нэмсэн Арга. Vol 14-р боть. Бээжин 2005.
17. Ёндонгомбо Ю. Тус амгалангийн сэрүүн гэрэлт шинэ сар. Vol 21-р боть. Бээжин 2005.

The Comparative Analysis of Drug Treatment for Latent Kidney inflammation based on various sources and works of tradical scholars

Sunduijams A¹, Seesregdorj S²

¹Department of Traditinal Medicine, International School of Mongolian Medicine, MNUMS

²International School of Mongolian Medicine, MNUMS

E-mail: Sundui870@gmail.com, Tel: +976-99069147

Background: In traditional medicine, diseases are generally classified into two categories: hot and cold. It is particularly emphasized to first identify diseases with a hot nature. Within this framework, we considered it important from both theoretical and clinical perspectives to study latent kidney heat disease, which is difficult to diagnose, prone to misdiagnosis, capable of exacerbating in both hot and cold directions, and requires multi-stage treatment.

Aim: To analyze the principles of treating latent kidney heat disease and medicinal treatments by comparing traditional medical sources, their explanations, and the works of scholars.

Materials and Methods: The study was conducted by examining relevant chapters from *The Four Foundations of Medicine*, its commentaries, and six scholarly works on the treatment of latent kidney heat disease. The methodology involved textual hermeneutics, comparative analysis, and critical synthesis.

Results: The original texts studied outline a three-stage treatment principle for latent kidney heat disease, described metaphorically as follows:

1. Initially, place the thief into the hole.
2. In the middle stage, release the smoke through the chimney.
3. Finally, eliminate the remaining heat with water.

These deep-rooted treatment principles indicate that traditional medicine has long recognized and effectively treated this disease within its theoretical and methodological framework. The primary sources examined documented a total of 33 medicinal formulations for treating latent kidney heat disease, categorized as follows: 5 decoctions (*tan*), 26 pulvis formulations (*takh*), 2 oil-based remedies (*toson em*). This variety of treatment options highlights the richness and adaptability of traditional medicine in addressing this condition. These medicines are applied according to the three treatment principles of the disease. First, to remove the phlegm and wind covering, *Jugandejid* and *Semberuu-4* are used. For releasing smoke through the chimney, decoction-type (*tan*) medicines are chosen, while pulvis-type (*takh*) medicines are prescribed based on the upper, middle, and lower intensities of the disease. This precise alignment of medicine selection resembles a key fitting into a lock. A unique characteristic of traditional medicine is the use of oil-based remedies (*toson em*) at the final stage of treatment to restore the body and balance the dual forces (*yin-yang*). Comparing the primary sources used in this study, we find that the principles of treating latent kidney heat disease and the selection of appropriate medicines follow the *FMT* (The Four Medical Tantras) text while incorporating additional refinements.

Conclusions:

1. A comparative analysis of medicinal treatments reveals that the medicines are prescribed in accordance with the three treatment principles, with their forms and compositions clearly specified.
2. Furthermore, the classification of medicines based on their strength and application to different disease intensities highlights a refined and well-structured standard treatment method.

Keywords: Kidney, Latent Heat, Treatment Principles, Medicinal Treatment.